



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/753

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 84 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар албан даалгавар, Засгийн газрын Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцийн 2021-2022 оны өвс бэлтгэлд зориулан Буянт сумын хадлангийн механикжсан салаанд бэлтгэсэн өвсийг тээвэрлэх шатахууны зардал 1 600 000 төгрөгийг хавсралтаар баталснаар зарцуулсугай.
2. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 1 600 000 төгрөг /нэг сая зургаан зуун мянга/-ийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 03-ны өдрийн
А/753 дугаар захирамжийн хавсралт



ХАДЛАНГИЙН МЕХАНИКЖСАН САЛААНЫ ӨВС ТАТАХ
ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Механикжсан салаа	Шатахууны зардал /төгрөгөөр/
1	Буянт сум	1 600 000
	Нийт	1 600 000

-оОо-